



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/108

Бөхт

Дотрын халдварт хордлого өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалт тогтоох тарилгыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.6 дахь заалт ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 1, 2 дугаар багийн малд Дотрын халдварт хордлого өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Б.Мядагмаа	(Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)
Гишүүд	Э.Сумъяа	(1 дүгээр багийн Засаг дарга)
	Д.Шинэбаяр	(2 дугаар багийн Засаг дарга)
	Б.Цэрэнням	(Бөхт таван эрдэнэ ХХК-ны малын их эмч)

2. Дотрын халдварт хордлого өвчний дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж шуурхай үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг тархвар зүйч (Б.Мядагмаа)-д тарилгын ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулж ажиллахыг Бөхт таван эрдэнэ ХХК (Б.Цэрэнням)-д, дотрын халдварт хордлого өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад малыг бүрэн хамруулах, малчид, мал бүхий иргэдэд тов мэдээг хүргэн бэлэн байдлыг хангуулахыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ